

## Coming to terms with Buddhism

## Хоолны өмнө хэлэх үг

~Хэлж үзье!~

Энэ сард РКК-ийн хоолны өмнө хэлдэг талархалын үгийг толилуулья.

Хоолны өмнөх талархалын үг Будда,байгалийн баялаг ба олон хүмүүст талархан зооглое.

Богино өгүүлбэр боловч үүнд гүн утга агуулагдсан байгаа.

Жишээлбэл,би дөнгөж агшаасан цав цагаан халуун будаанд дуртай.Гэвч энэхүү амттай будааг идье гэж бодоход л тэр маань нүдний өмнө шууд гараад ирэхгүй нь мэдээж.Будаа айганд ортол олон сар хоног дамжиж,олон хүний гарыг дамждаг байна.Энэ нь будааг ургуулан хураасан ноггчоос авахуулаад дэлгүүрт зөөсөн жолооч,зөөгч,будааг агшаасан ээж гээд олон хүний хөдөлмөр орно.Мөн будаа нь зөвхөн хүний хүчээр бий болохгүй.Нарны туяа,бороо,шороо газрын ачаар бүтдэг байна.Эдгээр нөхцөл нь зөвхөн будаа биш бусад бүх идээнд хамаарна.

Бид бүхэн ийнхүү байгал ба бусад хүмүүсийн хөдөлмөрийн ачаар амттай сайхан хоол идэж чаддаг байна.

Буддын сургаалд ийм нэгэн сургаал байдаг."Бүхий зүйлс ганцаар оршдоггүй".Энэ нь энэ дэлхийн ямар ч зүйл ч бүгд хоорондоо нарийн уялдаа холбоотой бөгөөд тусгаар тогтнодог юм гэж байхгүй гэсэн үг билээ.Хоолоо аваад үзэхэд л өөрөө бол ганцаараа оршдоггүй гэдгээ мэдэж болно.

Амттай халуун хоол дэргэд тавьсан байхад шууд идмээр санагдах боловч эхлээд хоолны өмнөх талархалын үгээ хэлж үзье.Хоол маань улам амттай сайхан санагдах болно доо.



## Интернетын харилцаа холбоо

~салбараас дэлхийг харах нь~

Японд жуулчдын нэрт газар болох Дайто дүүрэг.Тэнд энэ жил 50 жилийнхээ ойг угтаж буй Дайто салбар байдаг байна.Уг салбарт гадаадын жуулчид их ирдэг ба гишүүд тэд нарт буддын сургаалыг уйгагүй заадаг байна.

6 сарын 21-нд уг салбар нь 50 жилийнхээ ойн баяраа тэмдэглэсэн байна.Салбар дээр олон төрлийн үйл ажиллагаа зохиогдсон ба тэдгээрийн дотор интернетийг ашиглаж гадаадын салбартай харилцах үйл ажиллагаа зохиогджээ.

Оклахома нийгэмлэг,Гавайн нийгэмлэг,Солонгосын нийгэмлэг гээд 30 минутын хугацаанд тус бүрийн өдөр тутмын үйл ажиллагаа,аж амьдралаасаа хуваалцан ярилцсан байна.

Эцэст нь хэдийгээр бүгд өөр өөр газарт амьдардаг ч буддын ариун сургаалыг олон хүнд дамжуулахын төлөө хичээцгээе гэж бие биендээ амалсан байна.

# Баясгалантайгаар алхах нь

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч  
Нивано Ничикоу

## Энэ ертөнцөд буддын сургаалыг

РКК-д одоо бүх гишүүдэд Буддын ариун төрх болон адислалын бичгийг тарааж байгаа билээ.Энэ нь буддын сургаалын дагуу хүн бүр аз жаргалтай,утга дүүрэн амьдрал өнгөрүүлэхийн төлөө билээ.

Буддист бид нар Мөнхийн Үндсэн Буддагаас Сансарын Агуу Их Амийг хүртэн авсан билээ.Нэгэн Агуу Их Аминаас гаралтай бид Буддатай эцэг үрийн холбоотой юм.Эцгийн дүр болсон энэхүү Буддын хөргийг бид тус бүрийнхээ гэр орондоо байрлуулан тавьж,өдөр бүр дэргэд нь судраа уншиж мөргөснөөр сүсэглэлээ улам гүнзгийрүүлэн,амьдрал утга учир дүүрэн болж хувирана.

Мөн бид бүхэнд буддын сургаалыг дамжуулан зааж өгсөн эрхэм Үндэслэгч ба Мёко нарыгаа багшийн хувьд хүндлэн дээдлэж,гэртээ адислалыг нь тавьснаар шавийн үүргээ биелүүлж байгаагийн нэгэн жишээ юм.

Гэртээ гүнгэрваа тавина гэдэг бол Буддын сургаалыг дагаж,Буддаг энэ ертөнцөд хүрэлцэн ирэхийг хүсэж байгаа үйл билээ.Тийм учраас бид бүхэн гэртээ Буддын хөргийг бүтээн тавина гэдэг бол бид Үндсэн Буддагийн дуугүй сургаалыг зүрхнийхээ чихээр сонсож,Үндэслэгч ба Мёко багш нараа үлгэр жишээ болгон буддын замаар алхан явна гэсэн утгатай юм.

## Сэтгэлээ цэгцлэх нь

Гэртээ Буддын хөргийг тавьж,гүнгэрваа бүтээснээр бидний сүсэглэл хэв хэлбэртэй болж,зүрх сэтгэл ч гэсэн цэгцлэгдэнэ.Амилагдан амь яваадаа талархаж,өдөр бүр баяр баясгалан амсдаг болоод эхлэхээрээ элдэв юманд эгдүүцэж уурлахаа больж,сэтгэл санаа амгалан тайван болно.Жишээлбэл,урьд өмнө нь гүнгэрваагүй байсан айл гэртээ Буддын хөргийг байрлуулснаар идээгээ өргөн тавьдаг болж,гэр бүлийн харилцаа холбоо улам гүнзгийрсэн гэсэн яриа байдаг.

Буддын хөргийг хүртсэн айлын баяр баясгаланг хамтдаа баярлан амсаж,бүх гишүүд гэртээ гүнгэрваатай болохын төлөө шамдах хэрэгтэй.Ингэснээр аз жаргалтай гэр бүл улам их үржих болно.



## Merit Obtained Through Sutra Recitation

Тайнан нийгэмлэг Ко Шакуэй дарга

※ Энэхүү яриа нь 2 сарын 15-нд Тайнан нийгэмлэг дээр болсон юм. 2 хувааж толилууля.

Би РКК-д ороод 12 жил болж байна. Элсээд олон жил болж байгаа ч өөрийгөө жинхэнэ гишүүн болсон нь одоогийн үүргийг хүлээн авсан 4-5 жилийн өмнө юм шиг санагддаг. Тэрнээс өмнө бол хааяа л нэг ирж, ном уншиж, элдэв зүйл яриад л явчихдаг байсан. Нийгэмлэгийн үйл ажиллагаанд ч нээх их оролцохгүй, сургаалыг ч сайн ойлгодоггүй байлаа.

Удирдагч багшийн үүргийг хүлээн аваад нилээн хүнд ярихтай санагддаг байв. Тухайн үед бүр зугтмаар санагддаг байсан боловч сангагийн нөхөд, дарга нарынхаа ач тусаар бага багаар дасаж эхэлсэн юм.

Нийгэмлэгийн үйл ажиллагаа болон гишүүдийнхээ харилцаа холбооны ачаар олон зүйл суралцаж, Буддад бага багаар ойртож байгаа мэт санагдсан. Мөн сургаалыг заавал хэрэглэх хэрэгтэй гэдгийн ач холбогдлыг мэдэж, аливаа юманд зөвхөн өөрийн дураар хандаад байвал суралцах зүйл нь хязгаарлагдаад ирнэ гэдгийг ч ойлгосон юм.

Миний хувьд өнгөрсөн жил бол хамгийн их суралцаж чадсан жил болсон. Өнгөрсөн оны 10 сарын 4-нд аав маань нас барсан билээ. Сүүлийн мөчид би ах дүү нартайгаа хамт хэвтэж байсан эмнэлгийн өрөөнд нь орж, аавыг өнгөрсний дараа 8 цагийн туршид ном уншсан юм. Эхлээд маш хүнд гунигтай байсан боловч судраа уншиж эхлэнгүүт аяндаа сэтгэл хөнгөрч эхэлсэн билээ. Толгойнд аавын маань инээмсэглэл, хөгжилтэйгээр ярьж байсан байдлууд нь дурсагдан санагдаж байв. Буддын өөр шүтлэгтэй ах маань хүртэл судрын гайхамшигийг мэдэрсэн юм.

Эцэг маань үгүй болоод би эхний долоо хоног аавыгаа бурхан болж чадахын төлөө тувт судраа уншиж өнгөрөөсөн. Тэр үед сангагийн нөхдүүд ч ирж, хамтдаа ном уншсан билээ. Тэд нарын сайхан сэтгэлийг үнэхээр мэдэрч чадсан.

Сарын дараа Тайваны нэрт ууланд болох өвөг дээдсийн төлөө зориулсан буяны аянд оролцохоор болсон. Долоо хоног болсон тэрхүү аянд бид гэр

бүлээрээ 4 өдөр оролцсон юм. Буяны ёслол дуусах үед хүмүүс баруун зүг рүү харцгааж байв. Нэг нь тэнгэрт лянхуа цэцгийн хэлбэртэй үүл олноор байна гэж хэлэхэд бүгд тийш зүглэв. Үнэхээр ягаан өнгөтэй цэцгийн хэлбэртэй үүлнүүд ихээр байсан. Гэвч хэсэгхэн хугацааны дараа тэд бүгд гэнэт алга болсон юм. Дараагаар нь нөхөр болон эгч маань зүүн чиглэлд мөн тийм хэлбэртэй үүлнүүдийг олж харсан гэж ярьж байв. Би мөн л олж харах гэж зүтгэсэн боловч ерөөс олж харж чадаагүй билээ. Тэгээд өөрийн эрхгүй “Нөхөр эгч нар маань ямар ч шашин шүтлэггүй байж, яагаад тэр гайхамшигтай үзэгдлийг харж чадсан бол доо? Үнэнийг хэлэхэд би хэнээс ч илүү их өдөр бүр ном уншиж, шүтлэгтэй байхад” гэж бодож байлаа. Дараагаар нь сайвтар бодоод үзэхэд энэ нь бас л Буддын нигүүлсэхүй сэтгэлийн илрэл гэж мэдэрсэн. Тэрээр гайхамшигт үзэгдлээр шүтлэггүй хүмүүст сүсэглэлийн сэтгэл төрүүлж, шүтлэгтэй хүмүүст болохоор элдэв хэлбэрт автагдалгүй сургаалаа даган явахыг зааж байсан гэдгийг ойлгосон.

Одоо бодоод үзэхэд 4 жилийн өмнө анх удирдагч багшийн үүргийг хүлээн аваад, хүнд ярих гэсэн материалаа шууд олж, эрж хайж байсан буддын ном судрыг шууд олж чадаж байсан юм. Энэ нь Буддын нигүүлсэхүйн сэтгэл байсан бөгөөд сургаалыг үнэхээр сонирхож эхэлсэн надад том тусалцаа өгч байсан гэдгийг ч мэдэрч байна.



Ms. Wu (Left) receives the Certification of Family Education Training Program



